



Д. Шинэбаяр

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 7-р сарын 23 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг суралцуулах, зээл олгох тухай


Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцагчдыг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах ажлыг хариуцсан комиссын 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн **ТУШААХ НЬ** :

1. Дэд бүтцийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 1999 оны 5 дугаар сарын 19-ны 48 дугаар тушаалыг үндэслэн 1997 оны шилдэг оюутан **Нямдоржийн Энхзаяаг** АНУ-ын Шиллерийн Олон улсын их сургуульд олон улсын бизнесийн удирдлагын мэргэжлээр, мөн Яамны төрийн нарийн бичгийн даргын 1999 оны 7 дугаар сарын 26-ны 201 дүгээр тушаалыг үндэслэн 1998 оны шилдэг оюутан, "Залуу лидер" клубын өргөмжлөлт **Дашнямын Шинэбаярыг** ОХУ-ын Санкт-Петербургийн Зам тээврийн их сургуулийн магистрантурт ачаа тээврийн удирдлагын мэргэжлээр тус тус суралцуулсугай.

2. ОХУ-ын Ставрополийн гоц халдварт өвчин судлах хүрээлэнгийн аспирант **Д.Цэрэнноров, Б.Ариунсанаа** нарт хамгаалалтын зардалд зориулан эргэж төлөгдөх нөхцлөөр богино хугацааны зээл, Польш Улсад Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу аспирантурт суралцах АУИС-ийн багш **Дүгэрийн Даваадоржид** тэтгэлгийн зээл тус тус олгосугай.

3. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу **Н.Энхзаяа, Д.Шинэбаяр, Д.Цэрэнноров, Б.Ариунсанаа, Д.Даваадорж** нартай гэрээ байгуулан холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан / Б.Ганбат / - д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / С.Алтангэрэл / - д тус тус даалгасугай.

ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

 А.БАТТӨР